



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/86

Алтрага

Шинжилгээ хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3, Аймгийн Засаг даргын 2024 оны А/305 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын бруцеллёз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд азарганаас бусад хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний тандалт, шинжилгээг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд хийж гүцэтгэхийг “Чанартай сүрэг” ХХК-ны захирал (Л.Дүүжий), “Агар Мөрөн ЭНТ” хоршооны дарга (Б.Тунгалагтуул) нарт даалгасугай.

2. Шинжилгээний ажилд шаардлагатай шатахууны зардлыг шийдвэрлэж, туслалцаа үзүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга) нягтлан бодогч (Э.Ариунаа) нарт зөвшөөрсүгэй.

3. Шинжилгээ хийхэд шаардлагатай хүн хүч болон хээлтүүлэгч малыг товлосон газар, товлосон цаг хугацаанд нь бэлэн байлгахыг бүх багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Малд тандалт шинжилгээ хийх ажлын удирдамжийг нэгдүгээр, шинжилгээнд хамрагдах малын тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Даваажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010197

Сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар
сарын 21-ний өдрийн А/86 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

БРУЦЕЛЛЭЗ ӨВЧНИЙ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2024 оны 06 дугаар сарын.20

Нэг. Зорилго:

Аймгийн Засаг даргын 2024 оны А/305 захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын удирдамж, сумын Засаг даргын А/86 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд малаас хүнд дамжин халдварладаг бруцеллэз өвчний халдварлалтыг тогтоож, тухайн өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд удирдамжийн зорилго оршино.

Хоёр. Тандалт шинжилгээний хамрах хүрээ:

5-н багийн азарганаас бусад хээлтүүлэгч малд хийнэ.

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа:

2024 оны 06 дугаар сарын 20-ноос 2024 оны 08 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулна.

Дөрөв. Цусны дээж авах:

- Сумын азарганаас бусад бүх хээлтүүлэгч малаас цусны дээж авах ба заазлах малаас авахгүй шинээр үржилд ашиглах малыг нэмж оруулна.
- Авах цусны хэмжээ 5-7мл, ялгах ийлдэс 2мл хүртэл
- Авсан цусыг хөлдөөх дааруулах,хэт халуунд байлгаж болохгүй.
- Дээж авсаны дараа дулаан газарт хонуулж ийлдэсийг ялгаж цодонд хийж сайтар таглан номерийг зөв тод бичиж, дэс дараалалын дагуу хайрцаглана.
- Дээжийг зөв горимд хадгалан ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

Тав. Үр дүн: Энэхүү тандалт шинжилгээг хийж гүйцэтгэснээр:

1. Хээлтүүлэгч малын бруцеллэзын халдварлалтын түвшинг сум багийн түвшинд тогтоох
2. Ийлдэсийн санд баяжилт хийх.
3. Бруцеллэзтой тэмцэх ажлын хүрээнд хийсэн ажлыг баримтжуулж тайлагнах.

_____оОо_____